

УДИРДАХУЙН ЕРӨНХИЙ ОНОЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ЗАРИМ АСУУДАЛ

Я.ЦЭЛМЭН

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч

Хураангуй: Монголын ард түмэн бид “...төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн Үндсэн Хуулиндаа¹ тунхагласан.

Үндсэн хуулиндаа бэхжүүлсэн энэхүү эрхэм зорилгыг биелүүлхийн тулд бүх салбарын багшийг хөгжүүлэх, тэднээр дамжуулан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмээ хөгжүүлэх нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцсэн төрийн бодлого байх нь гарцаагүй байна гэдгийг өмнөх бүлгийн судалгаагаар дэвшүүлсэн.

Монгол улс их, дээд боловсрол эзэмших, эзэмшүүлэх явцад үүссэн нийгмийн тодорхой төрлийн харилцааг үүссэн цагаас нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж ирсэн. БНМАУ нь дунд сургуулийн багш нарыг бэлтгэх бодлогоо 1921 оноос хэрэгжүүлэн анхны багш нар бэлтгэгдэж эхэлсэн байдаг.

Багш нарын цалин хөлс², хангамж нь их, дээд сургуулийн багшийн хөгжилд шууд нөлөөлнө. Цаашилбал багшийн мэргэжил сонгон суралцах сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын оноо сайнгүй байгаа нь Монгол Улс боловсролын салбарын хөгжилд цаашид илүү анхаарах шаардлагатай болсоны илрэл юм.

Дэлхий нийтэд багшийн мэргэжлийг нийгмийн хамгийн чухал, ач холбогдолтойд тооцдог жишээ олон байдаг. Тухайлбал, АНУ боловсролын салбарт хамгийн их буюу 809 тэрбум доллар зарцуулдаг гэсэн судалгаа байна.

Түлхүүр үг: их сургууль, багш, хөгжил, эрх зүй.

Монгол улсын их, дээд сургуулийн багшийн хөгжлийн эрх зүйн орчны зарим асуудал

Монголын ард түмэн бид “...төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж эх орондоо

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл., 1992 он. №1

² Олон улсын жишиг ойлголтоор цалин гэдэг нь амьдралын зардалд бүрэн хүрээд, хуримтлал үүсгэх боломжтой мөнгөн дүнг хэлдэг байна.

хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцдуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн Үндсэн Хуулиндаа¹ тунхагласан.

Үндсэн хуулиндаа бэхжүүлсэн энэхүү эрхэм зорилгыг биелүүлхийн тулд бүх салбарын багшийг хөгжүүлэх. тэднээр дамжуулан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмээ хөгжүүлэх нь дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт нийцсэн төрийн бодлого байх нь гарцаагүй байна гэдгийг өмнөх бүлгийн судалгаагаар дэвшүүлсэн.

Монгол улс их, дээд боловсрол эзэмших, эзэмшүүлэх явцад үүссэн нийгмийн тодорхой төрлийн харилцааг үүссэн цагаас нь эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж ирсэн. БНМАУ нь дунд сургуулийн багш нарыг бэлтгэх бодлогоо 1921 оноос хэрэгжүүлэн анхны багш нар бэлтгэгдэж эхэлсэн байдаг.

Улмаар 1940 онд дунд боловсролын тогтолцоо бүрэлдэж, багшийн хэрэгцээ улам нэмэгдсэн. 1946 онд багшийн оройн институт, 1951 онд БНМАУ-ын Сайд Нарын Зөвлөлийн тогтоолоор Улсын багшийн институт байгуулагдсан. 1954 онд "Бүрэн дээд боловсролтой хүмүүсийг тодорхойлох тухай" БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн тогтоол, "Монгол улсын их сургуулийн ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" МАХН-ын төв хороо, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоол гарч байжээ. 1958 оноос анхны багш солилцооны хөтөлбөрөөр гадаад багш нартай туршлага солилцох болсон. Мөн 1963 онд "Сургууль амьдралын холбоог бэхжүүлэх, ардын боловсролын системийг сайжруулан хөгжүүлэх тухай" хуулийн дээд сургуулийн тухай бүлэгт дээд боловсролын эрх зүйн харилцааг тодорхой хэмжээгээр зохицуулж байсан билээ. Тухайн үеийн дээд боловсролын эрх зүйн харилцаа нь дээд сургуулийн удирдлага, үйл ажиллагааны зохион байгуулалт, оюутны ахуй хангамж. эчнээ оройн сургалт ба төгсөгчдийг хуваарилах асуудал, багш нарын хангамж, ажлын норм, эрдэм шинжилгээний ажил, түүний санхүүжилтын талаар засгийн газрын тогтоол, МАХН-ын төв хорооны тогтоол, дээрх эрх бүхий байгууллагуудын хамтарсан тогтоолын хүрээнд зохицуулж байсан байна. Энэ бүхнээс үзвэл 1963 оны боловсролын харилцааг зохицуулсан хуулиар гол гол асуудлыг нэг бүлэгт зохицуулснаас бусад дээд боловсролын нарийн төвөгтэй харилцааг ихэвчлэн эрх зүйн хэм хэмжээний актаар зохицуулж байсан гэж дүгнэж болохоор байна.

1974 оноос багш нарын мэргэжил дээшлүүлэх анхны курсыг байгуулснаар багшийн хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Үүний дараагаар 1982 онд БНМАУ-ын ардын их хурал "Ардын боловсролын тухай хуулийг батлан гаргасан. Энэ хуулиар мөн бүх шатны боловсролын харилцааг нэгтгэн зохицуулаж байсан. Түүний дээд боловсролын асуудлыг зохицуулсан бүлэгт дээд сургууль түүний үндсэн зорилт. дээд сургуульд элсэх. үйлдвэрлэлийн

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл., 1992 он. №1

дадлага хийх, диплом олгох. боловсон хүчний мэдлэгийг дээшлүүлэх зэрэг асуудлыг тусгажээ. 1991 онд Монгол Улсын Бага хурлаас "БНМАУ-ын боловсролын хуулийг батлан гаргасан. Энэ хууль нь өмнөх 1963. 1982 оны боловсролын тухай хуулийн нэгэн адил бүх шатны боловсролын харилцааг нэгтгэн зохицуулсан шинжтэй байсан хэдий ч тухайн үеийн нийгмийн тогтолцооны шинэчлэл, боловсролын хөгжлийн чиг хандлагыг харгалзан үзсэн шинэлэг зохицуулалтуудыг агуулсан. Тухайлбал: хувийн хэвшлийн боловсролын байгууллага байгуулж болох, албан болон албан бус аль ч хэлбэрээр боловсрол эзэмших боломжтой болох талаарх асуудлыг тусгасан. Энэ хууль нь сургуулийн тухай бус боловсролын тухай хууль байснаараа ихээхэн онцлогтой байсан байна.

1992 онд батлагдсан Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Улсын Их Хурлаас 1995 оны 36 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Боловсролын талаар баримтлах бодлого" батлагдсан. Мөн дээд боловсролын харилцааг тусгайлан зохицуулсан бие даасан хууль баталсан нь дээд боловсролын эрх зүйн зохицуулалтын хөгжилд ихээхэн давуу талтай гэж дүгнэж болох юм. 1995 оны дээд боловсролын тухай хуулиар дээд боловсролын зорилго, агуулга, дээд боловсролын байгууллага, түүний эрх, үүрэг, сургалтын зохион байгуулалт, удирдлага, багш суралцагчдын эрх үүрэг, эдийн засаг, нийгмийн халамжийн асуудал, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан байна. Энэ үед боловсролын салбарын эрх зүйн орчин бүрдүүлэхэд төрөөс үлэмж анхаарал тавьсан. Тухайлбал: Улсын төсвийн жилийн оролгын 20-иос доошгүй хувийг боловсролын санхүүжилтэнд зарцуулна. Мөн боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төвлөрсөн буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглосон. Санхүү татварын байгууллагад бүртгүүлж боловсролын байгууллагад хандивласан татвар төлөгчийн мөнгөн хөрөнгийг тухайн аж ахуй нэгж байгууллагын орлогын албан татвараас чөлөөлсөн зэрэг байна.

Монгол Улсын Их Хурлын 1995 онд батлагдсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-д багшийн талаар тухайлан авч үзсэн. "Багш сурган хүмүүжүүлэгчийн талаар" гэсэн тавдугаар бүлэгт: "Багш бол ард түмнийг соён гэгээрүүлэгч, хүүхэд залуучуудын оюун ухааныг хөгжүүлж, авьяас билгийг нээн илрүүлэгч, тэднийг амьдарч, хөдөлмөрлөх арга ухаанд сургаж, өөрийн биеэр үлгэрлэн хүмүүжүүлэгч гэж үзэж тэдний талаар дараах бодлогыг баримтлана гэж тэмдэглэсэн. Үүнд: 5/ багшийн сурган хүмүүжүүлэх ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн болон ёс зүйн шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх;6/ багшийн мэдлэг, чадвар, ажлын үр дүнг харгалзан тэдэнд "багшийн мэргэжлийн

зэрэг".ур чадварын нэмэгдэл" олгох, 8/ ерөнхий боловсролын сургууль. техникийн болон мэргэжлийн дунд сургуульд зохих диплом буюу бакалаврын зэрэгтэй. ИДСК үндсэн мэргэжлийн хичээлийг/-д магистраас доошгүй зэрэгтэй багшийг ажиллуулах ¹ зэргээр тодорхой бодлогын чиглэлүүдийг онцгойлсон байгаа бөгөөд энэхүү баримт бичиг нь одоогоос 23 жилийн өмнө батлагдсан ч гол утга санааг өнөөдөр манай оронд баримтлаж байгаа нь түүний агуулгын ач холбогдолыг тодотгож байна.

2002 оны Дээд боловсролын тухай хуульд ч их сургууль нь дээд сургууль болон коллежээс ихээхэн ялгаатай, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүргийн цар хүрээ өргөн. бие даасан онцгой статустай байгууллага байхаар тогтоосон байна. Дээд боловсролын тухай хуулиас гадна д нь их сургуулийн эрх зүйн орчинг тодорхой хэмжээгээр бүрдүүлэх нэг чухал эрх зүйн эх сурвалж юм. Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 -д зааснаар "эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг эрдэм шинжилгээний байгууллага гэнэ". Мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т зааснаар "эрдэм шинжилгээний байгууллагыг "эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага" хэлбэрээр байгуулж болно" гэж заасан. Манай хуулийн эдгээр зохицуулалтаас үзвэл их сургуулийн гүйцэтгэх нэг чухал үүрэг нь эрдэм шинжилгээ, судалгааны үүрэг мөн. Их сургууль нь мэргэжлийн бүх салбарт дээд боловсролтой мэргэжилтэн бэлдэх, төгсөлтийн дараа сургалт явуулах, шинжлэх ухааны болон, шинжлэх ухааны боловсролын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээний төв бүхий байгууллага байдаг. Ингээд үзэхээр манай өнөөгийн их сургуулиуд нь их сургуулийн жишигт хүрэх эсэх нь эргэлзээтэй .

2003 оны БСШУЯ -ны "Их, дээд сургууль, коллежийн багш албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлага" -д их, дээд сургуулийн багшийн чадварын гурвалыг "эрдэм шинжилгээ, судалгааны чадвар - бүтээлч чадвар, онолын мэдлэг, заах ур чадвар - ерөнхий соёл ба харилцааны чадвар" хэмээн томъёолсон байна.

Монгол Улсын Дээд Боловсролын Тухай Хуулийн* ² 15.1, 44.1, 44.2, 3.1, 13.1, 13.6 заалтуудаас их. дээд сургуулийн багшийн үйл ажиллагаа нь "мэдлэг үйлдвэрлэн түгээх-сургалт зохион байгуулах-эрдэм шинжилгээний ажил хийх", "өөрөө хөгжих-суралцагч бүрийг хөгжүүлэх-багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэх, хүнлэг харьцах, хүндэтгэлтэй хандах, хүүхдийг хайрлах хамгаалах, тэгш нөхцөл бүрдүүлэх. анхаарал тавих, харилцааг хүндэтгэн дээдлэх",

¹ Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. МУИХ., 1995

² Дээд боловсролын тухай Монгол улсын хууль. Төрийн мэдээлэл., 2002 он. №19

“мэргэжлийн өндөр түвшинд ажиллах-бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэх мэдлэг, чадвар. дадал эзэмшүүлж. соёл төлөвшүүлэх-судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх”, “мэдлэг, ур чадвараа тогтмол дээшлүүлэх-суралцагчидтай үр бүтээлтэй ажиллах. захиргааны ажилд оролцох-судалгаа шинжилгээний ажил хийх”, “иргэнд соёл боловсролыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах ажилд туслах-сургалт зохион байгуулах-эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулах”...зэргээр багшийн хөгжлийн үндсэн асуудлыг тодорхойлсон. Тус хуулийн долдугаар бүлгийн 13 дугаар зүйлд 13.1. Их сургууль, дээд сургууль. коллежид үндсэн мэргэжлийн хичээлийг магистр. түүнээс дээш зэрэгтэй багш заана.13.2.Их сургууль. дээд сургууль, коллежийн багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш заах арга зүй эзэмшсэн байна гэж онцлон тэмдэглэсэн байдагч "заах арга зүй" гэдэг томъёололыг тодотгон тайлбарлаагүй байна.

"Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого" хэрэгжих бүх үе шат (2007-2021он)-ын хугацаанд баримтлах боловсролын хөгжлийн бодлогод "ур чадвар сайтай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, дээд боловсрол олгох тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх бодлого баримтална. 2021 он гэхэд олон улсын жишигт нийцсэн боловсролын тогтолцоонд шилжинэ. Орон даяар оюун ухааныг эрхэмлэн дээдэлж амьдрах сэтгэл зүйн орчин бүрдүүлж, боловсролын бүх шатны сургалтыг 21 дүгээр зууны оюунжсан шинэ хандлагад зохицуулан өөрчилнө" гэж заажээ. Уг бодлогын хэрэгжилтийн эхний үе шат (2007-2015 он)-ын стратегийн зорилтод "Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ.

Хоёрдугаар үе шат (2016-2021он)-ын стратегийн зорилтод "Боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, чанарыг дээшлүүлэх замаар олон улсын жишигт ойртуулахад төрийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлнэ" гэж онцлон заажээ. Энэ хүрээнд “олон улсын бакалавр/IB/-ын диплом олгох сургуулийн тоог нэмэгдүүлэх, эдгээр сургуулийг төсөв, татварын бодлогоор дэмжих" дэд зорилт дэвшүүлсэн нь ИДСК-ийн багшийн хөгжилд шинэлэгээр хандах хэрэгцээг үүсгэж байна. Мөн хоёрдугаар үе шатын стратегийн зорилтод "Иргэд боловсролоо сайжруулж, ажил мэргэжлээрээ хөрвөн суралцаж байх бодит боломж олгосон боловсролын нээлттэй агуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгож хэрэгжүүлэх" хүрээнд "үндэсний тэргүүлэх мэргэжилтнийг төрийн бодлогоор дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлж, авъяас чадварыг хөхүүлэн дэмжих зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, түүнд зориулсан хөрөнгийг нэмэгдүүлж, оновчтой санхүүжүүлэх; "...их сургуулийн бие даасан байдал.

академик эрх чөлөөг баталгаажуулан, их сургуулийн шинжлэх ухааны чадавхийг дээшлүүлэхэд төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх зэрэг дэд зорилтуудыг чухалчлан тэмдэглэсэн нь ИДСК болон багшийн өмнө шинэ даалгавар, зорилтыг дэвшүүлжээ. Уг баримт бичигт бодлогын хэрэгжилтийн гол үр дүн, түүнийг хангах механизм бүлэгт эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат(2007-2015 он)-ын гол үр дүн нь “олон улсын стандартад ойртсон хоёроос доошгүй их сургуультай болох; мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үе шат (2016-2021 он)-ын “бүх шатны сургуульд хамран сургалт 100 хувьд хүрэх; олон улсын стандартад нийцсэн хөтөлбөртэй ерөнхий боловсролын болон их сургуулийн тоо нэмэгдэх; судалгаа боловсруулалтын санхүүжилтийн хэмжээг 2015 он гэхэд дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь, 2021 он гэхэд 3 хувьд хүргэх, энэ зардлын 1/3-г хувийн хэвшил санхүүжүүлдэг болох ¹ зэрэг үр дүнгээр хэмжигдэхийг онцгойлон авч үзсэн нь ИДСК-ийн багшийн хөгжлийн хандлагыг чиглүүлэхэд ач холбогдолтой байна.

Төрөөс багш нарын талаар барьж буй бодлого цаашид ч дэлхий нийтийн хөгжил үрүү тэмүүлэх чиглэлтэй байгааг Монгол Улсын засгийн газрын 2016-2020 он хүртэл хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн нийгмийн бодлогын боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 10 дахь хэсэгт заасан “Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ.” гэсэн заалтаас дүгнэж болно. Төрөөс боловсролын талаар барьж буй бодлогыг улам батлах үүднээс Монгол Улсын Ерөнхий сайдын У.Хүрэлсүхийн хэлсэн үгнээс иш татаж болхоор байна. Тухайлбал: .. “Монголчууд бид эрт дээр үеэсээ эрдэм ухааныг баян баяны дээд, эрхэм дээд баянд тооцож, эрдэм мэдлэгийг түгээгч багшийг шүтэж ирсэн оюунлаг ард түмэн билээ. Багшийн гараас хөтлөөгүй, багшаар бичиг эрдэм ухаан заалгаагүй хүмүүн гэж нэгээхэн ч үгүй биз ээ. Хүн бүхэнд л багштай холбоотой нандин сайхан дурсамж, гэгээлэг сайхан тэмүүлэл байдаг. Хүн бүхэн л багшаа хайрлаж, багшдаа сайн сайхныг хүсч, багшдаа туслахыг эрхэмлэж явдаг. Би ч бас өнөөдөр Монголын багш нарын энэ сайхан арга хэмжээнд оролцож байгаадаа баяртай байна...Засгийн газраас багш нарын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, боловсролын салбарын хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлнэ....Багш, нарын болон нийт төрийн албан хаагчдын цалин, хөлсийг нэмэгдүүлэх.

нийгмийн баталгааг хангах асуудал Засгийн газрын анхаарлын төвд байх болно гэдгийг тэмдэглэн хэлье"¹ гэжээ.

■"Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого \2014-2024\" -ын 1.2 -ийн "насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэх-иргэн бүр авьяас чадвараа хөгжүүлэх, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмших - ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөх"-ийг төрөөс багшийн дэмжих чухал тодорхойлолт гэж авч үзлээ. Уг баримт бичгийн 2.1.1 заалтаас, багшийн боловсрол нь хүртээмжтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, чанартай, тогтвортой, тасралтгүй, залгамж холбоотой, тэгш,хэрэгцээнд нийцсэн,соёл өв уламжлал,зан заншил бүгдэд ээлтэй,үйлчилгээ нь ил тод,нээлттэй,оролцоог дэмжсэн,олон хувилбартай байвал зохих байна.Энэ нь багш тасралтгүй,тогтвортой,тэгш хөгжихүйц нэгэн байна гэдгийг хэлж өгч байна.

"Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн хөгжлийн бодлого" —ын 4.11, "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн Үзэл баримтлал -2030" -ийн 2.2, 2.2.3, зорилт 4 зэргээс их, дээд сургуулийн багш "насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх", "мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн бий болгох", "тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох" үүрэг бүхий байна. Эл үүрэг их, дээд сургуулийн багшийг "тогтвортой хөгжихүйц багш хүн" байх шаардлага тавьсан гэж үзлээ.

Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор 2002 онд Боловсролын тухай багц хуулийг баталсан бөгөөд 2016 онд Боловсролын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 2018 онд Багшийн хөгжлийг дэмжих тухай² хуулийг батлан 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс даган мөрдөхөөр болсон.

Уг хууль нь Монгол Улсын боловсролын 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, Улсын Их Хурлын 45-р тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын 316-р тогтоолоор 2008 онд батлагдсан "Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр" зэрэг Монгол улсын хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгийн үзэл

¹ "Тогтвортой хөгжил—Ерөнхий боловсрол " сэдэвт багш нары хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдод МУ-ын Ерөнхий сайдын хэлсэн үгнээс. Төрийн ордон., 2018.

² Багшийн хөгжлийг дэмжих тухай. Төрийн мэдээлэл., 2018 он. №31

санаа зарчимд үндэслэсэн бөгөөд дээр дурьдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн боловсролын багц хуулийн үндсэн зарчим, багшийн хөгжлийн арга хэлбэр, хөгжлийн зарим нэр томьёог оновчтой болгох, багшийн оролцоо, хувь хүний хөгжил болон боловсролын хөгжил, мэргэжлийг дээшлүүлэх зэргийг тодорхой зохицуулсан байна.

Монгол Улсад багшийн хөгжлийн эрх зүйн орчин дээрх байдалтай байгаа бол харьцуулах үүднээс дэлхийн зарим улс орнуудын багштай холбогдох харилцааг зохицуулдаг эрх зүйн орчны туршлагаас нь судаллаа. Дэлхийн олон оронд их, дээд боловсролыг улсын хөгжлийн тулгуур үзүүлэлт хэмээн үзэж, багшийн хөгжлийн орчин, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл бололцоог чухалчилдаг аж.

ДҮГНЭЛТ: Төрөөс багш нарын талаар барьж буй бодлого цаашид ч дэлхий нийтийн хөгжил үрүү тэмүүлэх чиглэлтэй байгааг Монгол Улсын засгийн газрын 2016-2020 он хүртэл хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн нийгмийн бодлогын боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 10 дахь хэсэгт заасан "Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ." гэсэн заалтаас дүгнэж болно. Гэвч эдгээр хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж буй багшийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ нь багш хүн өөрөө хөгжих таатай боломжийг төдийлөн бүрдүүлээгүй байгаагийн зэрэгцээ ажил хөдөлмөрөө үнэлүүлэх зохистой системийг бүрдүүлж чадахгүй хэвээр байна.

Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэмд ажиллаж, амьдрах чадвартай, өөртөө итгэлтэй, үндэсний уламжлал, соёл зан заншлаа дээдэлдэг, сурах хүсэл тэмүүлэлтэй, эрдэм боловсролтой иргэнийг төлөвшүүлэхэд багшийн оролцоо дэмжлэг чухал билээ.

Багшийн хамгийн эрхэм үүрэг болох суралцагч нэг бүрийн авьяас, сонирхлыг дэмжин хөгжүүлэх ажиллагаа зохих ёсоор үнэлэгдэхгүй. багшийн нэр хүнд, мэргэжил, ур чадварын үнэлэмж доошилсон, боловсролын чанарыг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллагчдын идэвх, оролцоо хангалттай бус байгаа нь боловсролын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, тэдний онцлог, бусдаас ялгаатай байдлыг нээн илрүүлж, хөгжлийг нь дэмжиж буй багшийн тэргүүн туршлагыг олон нийтийн хүртээл болгох нь багшийн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэхэд түлхэц болох учиртай. Нөгөө талаар бүх шатны боловсролын байгууллагын мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний үндэсний цогц судалгаа өнөөг хүртэл хийгдээгүй байгаа нь багш хөгжих эрэлт хэрэгцээ, хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ нь үндэслэл муутай байна.

Багш нарын цалин хөлс ¹ . хангамж нь их, дээд сургуулийн багшийн хөгжилд шууд нөлөөлнө. Цаашилбал багшийн мэргэжил сонгон суралцах сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын оноо сайнгүй байгаа нь Монгол Улс боловсролын салбарын хөгжилд цаашид илүү анхаарах шаардлагатай болсоны илрэл юм. Гэвч эдгээр хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж буй багшийг хөгжүүлэх бодлого, арга хэмжээ нь багш хүн өөрөө хөгжих таатай боломжийг төдийлөн бүрдүүлээгүй байгаагийн зэрэгцээ ажил хөдөлмөрөө үнэлүүлэх зохистой системийг бүрдүүлж чадахгүй хэвээр байна.

САНАЛ: Шинээр мөрдөгдөх “Багшийн хөгжлийг дэмжих тухай” Монгол улсын хуулийн хүрээнд багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг дэмжих зорилгоор байгуулсан багшийн хөгжлийн төвийг олон улсын жишигт нийцсэн байдлаар ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, Их сургуулийн багшийг хөгжүүлэх жишиг хөтөлбөртэй болох, хэрэгжүүлэх, уг хөтөлбөрийг боловсруулахад багш нарын саналыг нэгтгэн тусгуулах, батлуулах, мөрдөж ажиллах;

Өөрсдийгөө хөгжүүлэх зорилгоор үүсгэсэн багш нарын сонирхлын бүлгийг байгуулахад удирдлагын зүгээс хуулийн хүрээнд дэмжих, тэдний үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх, тэдний хөгжүүлэхтэй холбоотой удирдлагын шийдвэр гаргалтанд багш нарын саналыг тусгаж хэвших;

Багшийн мэдлэг чадварын хөгжлийн түвшин, мэдлэг чадварын өсөлтийг үнэлж дүгнэх менежментийн загвар, суралцагч байгууллагын шалгуур үзүүлэлтүүдийн систем, ажлын байранд багшийг сургах, хөгжүүлэх асуудал, зарим шинэлэг загварууд, арга зүйн багцдалт зэргийг боловсруулан багшийн хөгжлийн менежментийг сайжруулах зэрэг болно.

Түүнчлэн Их сургууль хөгжин дэвжихийн, хүчирхэг байхын үндэс нь багшийг хэрхэн хөгжүүлснээс шалтгаалдаг тул тэднийг урамшуулан дэмжих, хөгжлийн бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, тасралтгүй хөгжих эрмэлзлэлийг бий болгох, боломжоор хангах замаар гарцаа тодорхойлж болох юм.

¹ Олон улсын жишиг ойлголтоор цалин гэдэг нь амьдралын зардалд бүрэн хүрээд, хуримтлал үүсгэх боломжтой мөнгөн дүнг хэлдэг байна.